



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/57/СТА-ТШЗ

Баянхонгор 2020 он	Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usuhuu83@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1. Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14

1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г ЭРДЭНЭМАНДАЛ АХЛАХ СУРГУУЛИЙН 7
ЗАХИРАЛ Л.ОНОНХҮҮ ТАНАА

2020.02.27 № 1/171

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\ 005020117

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Л.Ононхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Багшийн хөгжлийг дэмжиж, сурагч нэг бүрийн ёс зүй, харилцаа хандлагыг төлөвшүүлэхэд анхаарч, сургалтын чанарт ахиц гаргахад оршино".

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багшийн ажлын байранд тасралтгүй хөгжихөд дэмжлэг үзүүлэн, багш судлаач байх, багаар ажиллах чадварыг эрхэмлэх.
 - Багш, ажилтан, ажилчид сахилга хариуцлага, ёс зүйг чанд сахин, эерэг хандлагатай, бүтээлч байж, зөв үлгэр дуурайлалтай ажиллах.
 - Хичээл үйл ажиллагаанд тогтмол дүн шинжилгээ хийж, удирдлагын манлайллыг бүтээлчээр хэрэгжүүлэх.
 - ЭЭШ-ын хичээл тус бүрээр анализ хийж, хэмжээст оноог ахиулж, аймгийн дунджаас дээгүүр үзүүлэлттэй байх.
 - Сурлагын амжилтыг 10-с доошгүй хувиар ахиулж, математик, монгол хэл, англи хэлний хичээлийн сургалтын чанарт онцгой анхаарч, багш зохицуулах цагийг үр дүнтэй ашиглах.
 - Хүүхдэд тавигдах хараа хяналт, аюулгүй байдал, эрх хамгааллын талаар багш, эцэг эх, иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулах.
 - Хичээл үйл ажиллагаагаар хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжих, ёс зүй, харилцаа хандлагыг эергээр өөрчлөх соёл хүмүүжлийн ажлыг үр дүнтэй зохион байгуулах.
 - Үндэсний болон орон нутгийн онцлогтой хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэх.
 - Насан туршийн боловсролын үйлчилгээг иргэдийн хэрэгцээнд нийцсэн байдлаар хүртээмжтэй, чанартай зохион байгуулж, цахим контентийг дэмжин ажиллах
- Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.
- Төсвийн тухай хууль
 - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
 - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
 - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
 - Шилэн дансны тухай хууль
 - Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
 - Бага дунд боловсролын тухай хууль
 - Боловсролын тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 35 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2003059.9 мянган төгрөгөөс тооцон 40061.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 40061.2 мянган төгрөгөөр тооцсон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 172445.0 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	/мянган төгрөг/		
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	146,640.06	223,531.74	76,891.68
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00	00.00
33	АВЛАГА	1,414.13	6,927.81	5,513.67
34	УРЬДЧИЛГАА	00.00	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	145,225.92	216,603.93	71,378.01
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,887,390.72	3,982,944.04	95,553.32
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,178,040.09	4,421,146.43	243,106.33
39	ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	-290,649.37	-438,202.39	-147,553.02
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,034,030.78	4,206,475.77	172,445.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,034,030.78	4,206,475.77	172,445.00
51	Засгийн газрын хувь оролцоо	4,034,030.78	4,206,475.77	172,445.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,034,030.78	4,206,475.77	172,445.00

Бараа материалын дансны үлдэгдэл 71378.0 мянган төгрөгөөр өссөн ба сургуулийн 50 жилийн ойд зориулан өгсөн хандив, Нэгдсэн Үндэстний байгууллагын төсөл хөтөлбөрөөр нийлүүлэгдсэн 29580.8 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг бүртгэж, БСУГ-аас санхүүжүүлсэн төслөөр 4543.0 мянган төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн, төсвийн хөрөнгөөр сурах бичиг 8505.0 мянга, шүдний тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой эмнэлгийн хэрэгсэл, эм бэлдмэл 8082.8 мянган төгрөгөөр бэлтгэн, өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрээр 2740.9 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө акталсан зэрэг томоохон өөрчлөлтүүд гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 181217.9 мянга, үнэ төлбөргүй 83654.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 131 дүгээр тогтоолоор 21766.5 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4206475.8 мянган төгрөг болж 172445.0 мянган төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүн 172445.0 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 71802, 71806 кодтой хоёр хөтөлбөрт зориулан 1982297.2 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1574259.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 408037.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант онд улсын төсвөөс 1574259.3 мянга, орон нутгийн төсвөөс 408037.9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1982290.0 мянган төгрөг буюу 99.99 хувьтай байгаа нь улсын төсвөөс 1574259.3 мянга, орон нутгийн төсвөөс 408037.9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч урсгал үйл ажиллагааны зарцуулан 7.2 мянган төгрөг хэмнэгдэн төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх оны төвлөрүүлсэн үлдэгдэл 1138.6 мянга, БСУГ-аас 18544.6 мянган төгрөгийн санхүүжилт, 6095.4 мянган төгрөгийн түрээсийн орлого, 5957.5 мянган төгрөгийн гүнзгий ангийн төлбөр, 49174.5 мянган төгрөгийн хандив нийт 80910.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж зарцуулсныг дансны хуулгаар тулган баталгаажууллаа.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 35 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 21 эрсдэл тодорхойлж нийт 21 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 20813.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 626.2 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 9385.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 10801.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 20813.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 626.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 9385.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өглөө. Үүнд:

1.Тайлант онд спорт заалны түрээсийн орлого 200.0 мянган төгрөг дутуу төвлөрүүлсэн, ажилчидтай холбоотой цалингийн 426.2 мянган төгрөгийн авлага үүссэнийг санхүүгийн тайланд авлагаар тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг тус тус зөрчсөн, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2. Тайлант онд цалингийн зардлаас ажлаас чөлөөлөгдсөн ажилтны шүүхэд хандсан нэхэмжлэлийн дагуу гаргасан шүүхийн шийдвэрийг үндэслэн 9385.9 мянган төгрөгийн нөхөн олговор олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн, "Эрх ба үүрэг", гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Аудитаар илэрсэн 10801.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2.12.1. Тайлант онд тус байгууллагын 50 жилийн ой тохиосонтой холбоотой иргэн, аж ахуйн нэгжүүдээс нийт 86534.5 мянган төгрөгийн мөнгөн хандив өгснөөс 49174.5 мянган төгрөгийг нэмэлт дансаар, 37360.0 мянган төгрөгийг бэлнээр авч зарцуулсан ба тус асуудлаар Авлигатай тэмцэх газраас холбогдох албан тушаалтнуудыг шалгаж байгаа тул тус аудитаар авч үзээгүй болно. Мөн тус асуудлыг СТА-аар цаг хугацааны хувьд шалгах боломжгүй тул дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай.

2.12.2. Аймгийн Засаг дарга Г.Батжаргалын 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн Б/21 тоот захирамжаар ажлаас чөлөөлөгдсөн сургуулийн захирал Л.Ононхүүд Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 111/ШШ2018/0022 тоот шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт Эрдэнэмандал ахлах сургуулийн цалингийн зардлаас 9,385,861 төгрөгийг олгосон байна. Энэхүү зөрчил нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн тул Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэсэн заалтыг үндэслэн Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанд албан шаардлага хүргүүлсэн тул хэрэгжилтийн талаар арга хэмжээ авсан эсэхийг тодруулж үзэх.

2.12.3. Тайлант онд тэтгэвэрт гарч өндөр настны тэтгэвэрт гарсны тэтгэмж авсан 4 ажилтанд тус бүр 2 сарын цалинтай тэнцэх нийт 6301.6 мянган төгрөгийн тэтгэмжийг тус сургуулийн захирлын 2019 оны Б/103 тоот тушаалаар цалингийн зардлаас олгосон ч 2019 оны А/181 тоот тушаалаар тус Б/103 тоот тушаалаа хүчингүй болгож санхүүгийн тайланд авлагаар тусгасан байна. Тус асуудал Авлигатай тэмцэх газар шалгагдаж байгаа тул тус асуудалд зөвлөмж өгсөн тул дараагийн аудитаар зөвлөмжийн хэрэгжилтийн талаар тодруулж үзэх.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 118 мэдээллийг хугацаанд нь, 31 мэдээлэлд байршуулснаас хойш дахин засвар хийснээс хугацаа хоцроосон төлөвт орж, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	2	2	
4	Сар бүр	3	36	35	1	
5	Тухай бүр	8	96	80	16	
	Нийт	27	151	130	19	2

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. **Илрүүлэлт:** Тус байгууллагын биет бус хөрөнгөд 2010 оны барилгын засварын зураг төсвийн үнэ 4500.0 мянган төгрөгийг бүртгэсэн ба тус барилгад 2016 онд засвар хийсэн ч тус зураг төсвийг ашиглаагүй шинээр зураг төсөв хийлгэсэн байна.

1.2. **Эрсдэл:** Ашиглалтгүй биет бус хөрөнгө санхүүгийн тайланд бүртгэлтэй байх

1.3. **Өгсөн зөвлөмж:** Дансанд бүртгэлтэй зураг төсвийн үнийг яагаад их засварын санхүүжилтээс суутган тооцоогүй шалтгаан, цаашид ашиглах боломжтой эсэхийг тодруулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах

1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Цаашид алдааг давтан гаргахгүй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1 **Илрүүлэлт:** Тайлант онд тэтгэвэрт гарч өндөр настны тэтгэвэрт гарсны тэтгэмж авсан 4 ажилтанд тус бүр 2 сарын цалинтай тэнцэх нийт 6301.6 мянган төгрөгийн тэтгэмжийг тус сургуулийн захирлын 2019 оны Б/103 тоот тушаалаар цалингийн зардлаас олгож санхүүгийн тайланд авлагаар тусгасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2. **Эрсдэл:** Төсвийг зохистой удирдаагүйгээс төсвөөс илүү зардал гаргаж авлага үүссэн.

2.3 **Өгсөн зөвлөмж:** Тус авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллан мөнгийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх

2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	146,640,057.22	223,531,737.66
33	АВЛАГА	1,414,133.56	6,927,808.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	275,546.56	00.00
335	Бусад авлага	1,138,587.00	6,927,808.00
3351	Байгууллагаас авах авлага	1,138,587.00	200,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	6,727,808.00
35	БАРАА МАТЕРИАЛ	145,225,923.66	216,603,929.66
351	Түүхий эд материал	16,302,176.64	35,394,326.64
35110	Тусгай зориулалттай материал	15,902,326.64	31,163,826.64
35130	Эм боох материал	399,850.00	4,230,500.00
354	Хангамжийн материал	128,923,747.02	181,209,603.02
35410	Бичиг хэргийн материал	5,187,610.00	9,875,190.00
35420	Аж ахуйн материал	4,788,434.00	5,986,880.00
35450	Барилгын засварын материал	8,545,332.00	10,637,662.00
35470	Бусад хангамжийн материал	110,402,371.02	154,709,871.02
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,887,390,718.38	3,982,944,035.88
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,887,390,718.38	3,982,944,035.88
392	Биет хөрөнгө	3,251,940,718.38	3,347,494,035.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,125,684,656.36	3,266,984,656.36
39202	Хуримтлагдсан элэгдэл	-16,085,298.08	-136,413,116.62
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	207,417,363.95	230,500,256.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	-163,923,484.59	-176,915,960.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	155,867,074.75	213,210,834.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	-105,590,592.01	-119,823,312.89
39217	Ном	48,570,998.00	69,950,678.00
393	Биет бус хөрөнгө	635,450,000.00	635,450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	640,500,000.00	640,500,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-5,050,000.00	-5,050,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,034,030,775.60	4,206,475,773.54
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,034,030,775.60	4,206,475,773.54
51	Засгийн газрын хувь оролцоо	4,034,030,775.60	4,206,475,773.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,468,610,681.55	1,468,610,681.55
51101	Өмч: - төрийн	1,468,610,681.55	1,468,610,681.55
512	Хуримтлагдсан үр дүн	530,650,450.00	703,095,447.94
51210	Өмнөх үеийн үр дүн	530,650,450.00	530,650,450.00
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	172,444,997.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,034,769,644.05	2,034,769,644.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,034,030,775.60	4,206,475,773.54

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,289,501,121.60	2,175,504,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	798,677,106.60	125,488,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	798,677,106.60	125,488,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	798,677,106.60	125,488,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,175,000.00	12,252,880.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	797,502,106.60	113,235,720.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	37,804,415.00	475,757,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,453,019,600.00	1,574,259,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,126,337.00	67,719,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,126,337.00	18,544,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	49,174,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	408,037,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	408,037,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	22,678,078.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	22,678,078.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,546,009,873.87	2,003,059,902.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,546,009,873.87	2,003,059,902.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,448,718,810.51	1,933,722,864.65
2101	Цалин хөлө болон нэмэгдэл урамшил	873,051,369.00	1,127,252,201.00
210101	Үндсэн цалин	679,111,814.00	851,173,793.00
210102	Нэмэгдэл	133,685,116.00	184,807,838.00
210104	Урамшуулал	60,254,439.00	91,270,570.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,815,572.44	141,580,628.35
210201	Тэтгэврийн даатгал	71,277,343.00	97,180,557.35
210202	Тэтгэмжийн даатгал	9,015,430.53	11,416,478.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,527,098.91	8,974,464.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,726,883.00	2,182,648.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,268,817.00	21,826,481.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	326,261,910.14	401,537,900.00
210301	Гэрэл, цахилгаан	10,852,806.00	11,561,516.00
210302	Түлц, халаалт	259,332,468.14	334,513,280.00
210303	Цэвэр, бохир ус	56,076,636.00	55,463,104.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,549,608.60	24,624,035.80
210401	Бичиг хэрэг	5,531,830.00	9,485,560.00
210402	Тээвэр, шатахуун	2,011,939.00	3,143,000.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	4,436,299.50	4,641,471.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	510,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,812,834.00	4,103,104.00
210408	Бараа материал акталсны зардал	1,756,706.10	2,740,900.00
2105	Нормативт зардал	343,250.00	695,650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	343,250.00	695,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,261,845.00	20,825,637.00
210604	Урсгал засвар	13,261,845.00	20,825,637.00
2107	Төмилөлт, зочны зардал	993,900.00	4,650,000.00
210702	Дотоод албан төмилөлт	993,900.00	4,650,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,565,200.00	38,098,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,565,200.00	37,498,250.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	109,876,155.33	174,458,562.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,443,123.00	2,910,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,730,000.00	2,229,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	102,703,032.33	169,319,562.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,291,063.36	69,337,037.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,248,978.00	69,329,809.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	22,678,078.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,632,200.00	52,994,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20,292,700.00	7,569,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	646,000.00	8,765,809.00

**Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	42,085.36	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,085.36	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	7,228.41
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	7,228.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	743,491,247.73	172,444,997.94
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	300,364.32	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	300,364.32	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-300,364.32	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	743,190,883.41	172,444,997.94

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,491,999,015.00	2,063,207,767.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,175,000.00	12,052,880.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,175,000.00	12,052,880.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,175,000.00	12,052,880.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,175,000.00	12,052,880.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,490,824,015.00	2,051,154,887.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,453,019,600.00	1,574,259,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,126,337.00	68,857,687.00
131104	Дэд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,126,337.00	19,683,187.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	49,174,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	408,037,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	408,037,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	22,678,078.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	22,678,078.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,491,999,015.00	2,063,207,767.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,491,999,015.00	2,063,207,767.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,393,569,364.64	1,993,559,938.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	869,990,488.00	1,126,231,599.79
210101	Үндсэн цалин	681,535,088.00	888,316,899.79
210102	Нэмэгдэл	122,357,700.00	100,146,700.00
210104	Урамшуулал	66,097,700.00	137,768,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,152,000.00	147,377,000.00
210201	Тэтгэврийн даатгал	72,555,500.00	104,240,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,148,900.00	10,784,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,319,400.00	8,627,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,829,300.00	2,156,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,298,900.00	21,568,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	326,407,410.14	401,537,900.00
210301	Гэрэл, цахилгаан	10,998,306.00	11,561,516.00
210302	Түлш, халаалт	259,332,468.14	334,513,280.00
210303	Цэвэр, бохир ус	56,076,636.00	55,463,104.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,012,991.50	21,190,299.80
210401	Бичиг хэрэг	3,442,260.00	4,841,708.00
210402	Тээвэр, шатахуун	1,941,939.00	3,143,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,285,149.50	4,264,471.80
210404	Ном, хэвлэл	1,595,955.00	5,695,760.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,747,688.00	2,945,360.00
2105	Нормативт зардал	593,450.00	5,843,390.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	209,850.00	4,563,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	383,600.00	1,279,590.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,312,995.00	170,409,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	6,500,000.00
210602	Тавилга	00.00	25,209,500.00
210604	Урсгал засвар	21,312,995.00	138,700,000.00
2107	Томилолт, зочны зардал	993,900.00	4,650,000.00
210702	Догоод албан томиллолт	993,900.00	4,650,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,903,200.00	76,116,349.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,903,200.00	75,516,349.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,202,930.00	40,203,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,848,450.00	28,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,354,480.00	12,203,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,429,650.36	69,647,828.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,248,978.00	69,640,600.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	22,678,078.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,632,200.00	52,994,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20,292,700.00	7,569,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	646,000.00	9,076,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	42,085.36	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,085.36	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,138,587.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,138,587.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	7,228.41
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	7,228.41
9	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	530,650,450.00	4,034,030,775.60
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	530,650,450.00	4,034,030,775.60
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	530,650,450.00	4,034,030,775.60
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	172,444,997.94	172,444,997.94
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	703,095,447.94	4,206,475,773.54

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,982,297,200.00	1,982,289,971.59	7228.41	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,982,297,200.00	1,982,289,971.59	7228.41	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,920,225,400.00	1,920,218,971.59	6428.41	100.0
2101	Цалин хөлө болон нэмэгдэл урамшил	1,126,231,600.00	1,126,231,599.79	0.21	100.0
210101	Үндсэн цалин	888,316,900.00	888,316,899.79	0.21	100.0
210102	Нэмэгдэл	100,146,700.00	100,146,700.00	0.00	100.0
210104	Урамшуулал	137,768,000.00	137,768,000.00	0.00	100.0

**Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,377,000.00	147,377,000.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	104,240,400.00	104,240,400.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	10,784,100.00	10,784,100.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,627,400.00	8,627,400.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,156,900.00	2,156,900.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	21,568,200.00	21,568,200.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	401,537,900.00	401,537,900.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	10,246,500.00	11,561,516.00	-1315016.00	112.8
210302	Түлш, халаалт	333,491,400.00	334,513,280.00	-1021880.00	100.3
210303	Цэвэр, бохир ус	57,800,000.00	55,463,104.00	2336896.00	96.0
2104	Хангамж, бараа материалын зардал	21,190,300.00	21,190,299.80	0.20	100.0
210401	Бичиг хэрэг	4,519,200.00	4,841,708.00	-322508.00	107.1
210402	Тээвэр, шатахуун	3,143,000.00	3,143,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, ингернэтийн төлбөр	4,488,900.00	4,264,471.80	224428.20	95.0
210404	Ном, хэвлэл	5,659,800.00	5,695,760.00	-35960.00	100.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	300,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,079,400.00	2,945,360.00	134040.00	95.6
2105	Нормативт зардал	5,843,400.00	5,843,390.00	10.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,563,800.00	4,563,800.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн элдэл	1,279,600.00	1,279,590.00	10.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	170,409,500.00	170,409,500.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,109,500.00	6,500,000.00	-1390500.00	127.2
210602	Тавилга	26,600,000.00	25,209,500.00	1390500.00	94.8
210604	Урсгал засвар	138,700,000.00	138,700,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	4,656,400.00	4,650,000.00	6400.00	99.9
210702	Дотоод албан томилолт	4,656,400.00	4,650,000.00	6400.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,775,400.00	2,775,382.00	18.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,175,400.00	2,175,382.00	18.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40203900.00	40203900.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,000,000.00	28,000,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	12,203,900.00	12,203,900.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62071800.00	62071000.00	800.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,071,800.00	62,071,000.00	800.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	52,995,200.00	52,994,400.00	800.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,076,600.00	9,076,600.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,982,297,200.00	1,982,289,971.59	7228.41	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,574,259,300.00	1,574,252,071.59	7228.41	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,574,259,300.00	1,574,252,071.59	7228.41	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	408,037,900.00	408,037,900.00	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	408,037,900.00	408,037,900.00	0.00	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	106.00	105.00	1.00	99.1
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	85.00	84.00	1.00	98.8
620003	Үйлчлэх ажилтан	21.00	21.00	0.00	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,381.00	1,217.00	164.00	88.1
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧ	1,381.00	1,217.00	164.00	88.1
630001	Төрийн өмчигч ЕБС	1,381.00	1,217.00	164.00	88.1
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	107.00	106.00	1.00	99.1
650004	СББ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	79.00	79.00	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	28.00	27.00	1.00	96.4

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15126337.00	80,910,567.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15126337.00	80,910,567.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13987750.00	73,340,967.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	73,340,967.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		73,340,967.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13987750.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13987750.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1138587.00	7569600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	7,569,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		7,569,600.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1138587.00	00.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	1138587.00	00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15126337.00	68857687.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15126337.00	68,857,687.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15126337.00	19,683,187.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		49,174,500.00
	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР

Ж.ӨСӨХБАЯР

Огноо: 2020.02.27

Анхан шатанд хянасан:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

Огноо: 2020.02.27

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

Огноо: 2020.02.27

